



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 1/1488

Чингис хот

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", 29.1.6-ын "а", 29.2, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн 3.3.1 2, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын А/241 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан дархлаажуулалтад нийт үхэр, болон эрсдэл бүхий Баянхутаг, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Баян-Овоо, Мөрөн, Хэрлэн сумын бог малыг тус бүр хамруулах ажлыг 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 15 хоногийн хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын ажлын хэсэгт Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн, багийн Засаг дарга, төрийн албан хаагчдыг томилон ажиллуулж, тогтоосон хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулахыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/-т, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ/-т, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус хариуцуулсугай.

4. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, дархлаажуулалтын дүнг танилцуулах, санхүүжилтийн баримт материалыг холбогдох яаманд хүргүүлэх ажлыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010817